



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 8/40


Улаанбаатар хот

Д.Мөнгөндуулгыг сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус ТУШААХ нь:

1. Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг чадавхижуулах цогц модуль сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Дашдаваагийн Мөнгөндуулгыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. Д.Мөнгөндуулгад дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

